

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаанд урьж байна.

Замын-Үүд сумын Засаг-даргын 2018 оны А/05 тоот захирамжийг үндэслэн дор дурьдсан байршилтай газарт газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зарлаж байна. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газарт 2018 оны 02-р сарын 21-ны өдөр 15.00 цагт танхимын хэлбэрээр явагдана.

№	Газрын байршил	Зориулалт	Талбай /га/	Дуудлага худалдааны анхны үнэ /мян.төг/	Дэнчин	Газар эзэмших хугацаа
1	Бохир ус шахуургын станцын баруун талд, авто замын баруун талд	Үйлчилгээ	0.05	480 000	48 000	15 жил
2	Бохир ус шахуургын станцын баруун талд, авто замын баруун талд	Үйлчилгээ	0.05	480 000	48 000	15 жил
3	Сүлд баг, Хөгжлийн 208 тоот	Үйлчилгээ	0.14	1 344 000	134 400	15 жил
4	1 баг Хаанбанкны зүүн талд	Үйлчилгээ	0.0279	267 480	26 748	15 жил
5	Сүлд баг “Монгаз”ХХК-н баруун талд	Төмөр хоёрдогч түүхий эд авах боловсруулах цэг	0.496	3 968 000	396 800	15 жил
6	1 баг 131-р байрны баруун талд	Үйлчилгээ	0.05	480 000	48 000	15 жил
7	“Э-Транс”ХХК-н баруун талд	Үйлчилгээ /талбайн хэмжээ нэмэх/	0.1	960 000	96 000	15 жил
8	3 баг Шаргын овооны баруун талд	Малын гоц халдварт өвчингүй эрүүл бүс	500	1 600 000 000	160 000 000	15 жил

Дуудлага худалдааг Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “ Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх , ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу явуулах ба ялагчтай дээр журам болон Монгол Улсын “Газрын тухай” хуулийн дагуу гэрээ байгуулна.

Дуудлага худалдаанд оролцогчдын хүсэлтийг дуудлага худалдаа явагдахаас 3 хоногийн өмнөөс эхлэн Замын-Үүд сумын ЗДТГазар газар дээр битүүмжилсэн хайрцгаар хүлээн авах ба бүртгэлийн хайрцгийг дуудлага худалдаа явагдахаас 30 минутын өмнө хаана.

Дуудлага худалдаанд оролцогчид дараах материалуудыг бүрдүүлнэ. Үүнд:

- Дуудлага худалдаанд оролцох хүсэлт / Замын-Үүд сумын газрын даамалаас авна/
- Иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Дэнчин төлсөн баримт; /Төрийн сан банк 060000961 тоот дансанд тушаана
- Дуудлага худалдаанд иргэнийг төлөөлж оролцох тохиолдолд тухайн иргэний олгосон нотариатчаар гэрчлүүлсэн итгэмжлэл;

11. Дуудлага худалдаанд аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж оролцох тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын олгосон итгэмжлэл.

12. Улсын тэмдэгтийн хураамж-12500 төгрөг-Төрийн сан банк 061400941 тоот дансанд тушаана.

Дуудлага худалдаа явуулах газрын байршил, хил хязгаарыг харуулсан схем зураг болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг 91020011 утсаар болон Замын-Үүд сумын ЗДТГазарт ирж лавлана уу.

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

